

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

20 20 оны 01 дугаар
сарын 20 өдөр

Дугаар 0044/2020

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс:

| | | |
|---|---|---------------------------------|
| Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт: | Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо “320 хүүхдийн 88 дугаар сургуулийн дулаан техникийн засвар”-ын ажлын зураг төсөл, төсөв Шифр: ЛК-124/19-19 | |
| Хүчин чадал: | Барилгын хэмжээ: Тэнхлэгээрээ 54.0 м х 48.3 м хэмжээтэй, 3 блок /320 хүүхэд/ Давхрын тоо: ± 0.00 түвшнээс дээш 2 давхар Барилгын ажлын талбай: S= 2209.9 м ² | |
| Захиалагч: | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг | |
| Санхүүжилтийн эх үүсвэр: | Гадаадын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар | |
| Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр: | “Лайн констракшн” ХХК | |
| Регистрийн дугаар: | РД: 5368065 | |
| Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа: | 2022.01.30 | |
| Ажлын төрөл: | 1.2.1, 1.2.5, 1.2.2, 1.2.6 заалтын дагуу | |
| Зураг төсөл боловсруулах үндэслэл: | | |
| Зургийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн захирлын баталсан засварын ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар | |
| Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн захирал, “Лайн констракшн” ХХК-ийн захирал нарын хороонд 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан 83334184 дугаартай зураг төслийн ажил гүйцэтгэх гэрээ | |
| Зөвшөөрөлцсөн байгууллагууд: | | |
| Нийслэлийн боловсролын газрын дарга | | Ж.Гантулга |
| Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн мэргэжилтэн | | С.Түвшинхүү |
| Барилга, байгууламжийн зураг төслийн бүрэлдэхүүн: | | |
| Зураг төслийн иж бүрдэл: | Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Магадлал хийсэн экспертийн нэр: |
| Барилга архитектур: | “Лайн констракшн” ХХК | Ц.Бат-Эрдэнэ |
| Барилгын төсөв: | “Лайн констракшн” ХХК | Г.Гантуяа |
| Нэгтгэсэн дүгнэлт: /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/ | | |

Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;

Барилга, байгууламж баригдах газрын байгаль, цаг уурын ерөнхий өгөгдөл:

Гадна агаарын температур -39°C

Цасны ачаалал 50 кг/м^2

Салхины ачаалал 35 кг/м^2

Галд тэсвэршилтийн зэрэг: II

Барилга байгууламжийн техникийн шийдэл:

Барилга нь тэнхлэгээрээ $54.0 \text{ м} \times 48.3 \text{ м}$ хэмжээтэй, 3 блок, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар барилга байна.

Барилгын засвар:

Барилгын дулаан алдагдлыг бууруулах зорилгоор дараах засварын ажлуудыг хийсэн байна. Үүнд:

Дээвэр: Одоо байгаа хавтгай дээврийн хогийг цэвэрлэж 200 мм -ийн зузаан хөөсөнцөр хавтангаар дулаалж дээр нь 90 мм -ийн зузаан хамгаалалтын бетон тэгшилгээ хийж 2 үе ус тусгаарлагч хар цаас наах мөн борооны ус зайлуулах шугам хоолой солих, 120 мм -ийн тоосгоор салхивчийн яндан өрөх, 380 мм -ийн тоосгоор парпет нэмж өрөх ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.

Саравч дулаалах: Саравчны дээд талыг 50 мм -ийн зузаан хөөсөнцөр хавтангаар дулаалж дээр нь 60 мм -ийн зузаан хамгаалалтын бетон тэгшилгээ, 30 мм -ийн зузаан цементэн тэгшилгээ хийж 2 үе ус тусгаарлагч хар цаас наах мөн доод талыг 50 мм -ийн зузаан хөөсөнцөр хавтангаар дулаалж чулуут шавардлага өнгөлгөө хийхээр төлөвлөсөн байна.

Суурь: Барилын хуучин хаяавчийг буулгаж суурийн хананд 100 мм -ийн зузаан хөөсөнцөр хавтан дулаалга хийх, 2 үе ус тусгаарлагч түрхлэг хийх, 1 үе ус тусгаарлагч плёнк наах, суурийн хажуугаар хайрга хийж нягтруулах, бетон хаяавч цутгах зэрэг ажлуудыг хийхээр зураг төсөлд тусгасан байна

Гадна хана: Гадна ханыг 150 мм -ийн зузаан хөөсөнцөр хавтангаар дулаалж чулуут шавардлага өнгөлгөө хийхээр төлөвлөсөн байна.

Хаалга, цонх: Одоо байгаа бүх цонхыг 3 давхар шилтэй вакум цонхоор солих мөн усны хаялага төмөр, модон тавцанг их бүрэн солих, гадна хаалга иж бүрэн солих, хаалга, цонхны амалгааны засварын ажил хийхээр зураг төсөлд тусгасан байна.

Дотор засал: Зурагт заагдсан өрөө тасалгааны хана, таазны хуучин будгийг 100% хусаж цэвэрлэж замаскан тэгшилгээ хийж эмульсэн будгаар будахаар төлөвлөсөн байна.

Шалны ажил: Зурагт заасан өрөө, тасалгааны хулдаас, керамик хавтан шалыг буулгаж дахин шинээр хийх, шалны банзыг 25% хүртэл сольж өнгийн будгаар будах төлөвлөсөн байна.

Бусад ажил: Гадна шат довжоо, цэцгийн мандлын тоосгон хана шавардах, саарал өнгийн будах,

| | |
|--|---|
| | хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам хийх, налуу замын төмөр хайс хийж будах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна. |
| Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх; | Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал: Экспертүүдийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг төсөлд засвар өөрчлөлтүүдийг хийсэн байна. |
| Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх; | Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан байдал: "320 хүүхдийн 88 дугаар сургуулийн дулаан техникийн засвар"-ын ажил хийснээр хүүхдүүд ая тухтай цэвэр орчинд сурч хүмүүжих таатай нөхцөл бүрдэнэ. |

Төсөвт өртгийн нэгдсэн товчоо

| № | Тодорхойлолт | Төсөвт өртөг /төг/ | Хүчин чадал | Нэгж өртөг /төг/ |
|---------------------------|--|----------------------|--------------------|------------------|
| 1 | Барилгын дулаан техникийн засварын ажил: | | | |
| 1.1 | Барилгын засвар /м2/: Барилгын суурь, дээвэр, гадна хана, саравч 50 мм, 100 мм, 150 мм-ийн зузаан хөөсөнцөр хавтангаар дулаалах, гадна довжоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам хийх, дотор засал, шалны ажлын засвар, хаалга цонх солих | 455,556,622.0 | 2,209.9 | 206,143.5 |
| Хэсгийн дүн: | | 455,556,622.0 | 2,209.9 | 206,143.5 |
| НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ: | | | 455,556,622 | |

Төсөв: Эксперт нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо "320 хүүхдийн 88 дугаар сургуулийн дулаан техникийн засвар"-ын ажлын төсөвт өртгийг **455,556,622** (дөрвөн зуун тавин таван сая таван зуун тавин зургаан мянга зургаан зуун хорин хоёр) төгрөгөөр хянасан байна.

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиох хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо "320 хүүхдийн 88 дугаар сургуулийн дулаан техникийн засвар"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12/-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Нэгтгэсэн дүгнэлт нь экспертүүдийн **4** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

Ц.АМАРСАНАА

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.ЭНХБОЛД

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.САРАНТУЯА

